

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/131/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг
2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 90900910

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478

Цахим хаяг:

Аудитор:

Г.Намчинсүрэн

Утас: 91995689

Цахим хаяг: Namchinsuren999@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
	Error! Bookmark not defined.	

1 Аудитын гэрчилгээ


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020-01-31 № 18

тантай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020036

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

2 Аудитын тайлан

2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг СХХэлтсийн дарга Бүрэнтуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 01 дүгээр сарын 29-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газар-ын Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Булган аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс нь “Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино”.гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тус байгууллага нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;

- Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлогоор дэмжиж, Монгол улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;

- Олон улсын шаардлагад нийцсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Бүтээгдэхүүн үйлчилгээний болон удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000 НАССР)-ны баталгаажуулалтын үйл ажиллагаагаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцөлийг бүрдүүлэх;

- Сорьцын баталгааг олон улсын түвшинд хүргэх, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хэмжил зүйн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Тухайн байгууллага Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2006 онд боловсруулан батлуулсан боловч өнөөг хүртэл холбогдох дүрэм журам шинэчлэгдэхэд НБББББ-ийг тухайн өөрчлөлттэй уялдуулан шинэчлээгүй байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “СИ-ТИ-ЭС” программ хангамж ашигладаг байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 24 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “ Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 255621.5 мянган төгрөгөөс тооцон 5362.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 5362.0 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход улсын төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдаагүй орлого нэмэгдэж тооцогдоно, нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.холбоотой болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 885.8 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	655.5	460.0	-195.5
Урьдчилгаа			

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал	9130.6	10212.0	1081.4
Үндсэн хөрөнгө	302193.2	278741.5	-23451.6
Нийт хөрөнгө	311979.4	289413.6	-22565.7
Өр төлбөр	686.2	2202.6	1516.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	311292.8	284210.9	-24081.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	311979.4	289413.6	-22565.7

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны авлагын үлдэгдлээс 195.5 мянган төгрөгийн авлага барагдсан нь шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014 онуудад үүссэн, он удаан жил болсон 460.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд бараа материал 11984.3 мянган төгрөгөөр худалдан авсан боловч тайлант онд худалдан авсан бараа материалыг зарцуулаагүй нь тайлант оны бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй 0.0 мянган төгрөгийн бараа материал байна.

2019 оны эцэст бараа материалын худалдан авалт хийгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн элэгдэл 23451.6 мянган төгрөг хасагдсанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь халаалтын зардал өсөж батлагдсан төсөв хүрэлцээгүй нийт өглөг 1515.0 мянган төгрөгөөр өссөн нь шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэлд барьцаа хөрөнгө эзлээгүй болно

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 287210.9 мянган төгрөг болж 24081.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд -24081.8 мянган төгрөгийн үйл ажиллагааны үр дүнтэй ажилласан нь шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгатай холбоотой бичилт гараагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Стандарт хэмжил зүйн хэлтэс нь тайлант онд 30000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 35164.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Баталгаажуулалтын орлого	30000.0	35164.9	5164.9	117
Нийт дүн	30000.0	35164.9	5164.9	117

Төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагааны орлого 5164.9 мянган төгрөгөөр давсан нь үйлчилүүлэгч байгууллагын тоо өссөн мөн үйлчилгээний үнэ хөлс нэмэгдснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны зардалд 201214.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 200958.9 мянган төгрөгийг урсгал зардалд мянган төгрөгийг зарцуулжээ.

Нийт зардлын 201214.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 35172.9 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий орлогын нэр төрөл, шалтгаан/

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий зардлын нэр төрөл, шалтгаан/

Хөрөнгө оруулалтын 0 төсөл, арга хэмжээнд 0.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 0.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд төсвийн зарлагыг 257.1 мянган төгрөгөөр хэмнэсэн нь зарцуулж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 29.4, бусад бараа үйлчилгээний зардлаас томилолт 227.7, зочны зардлаас 0.13 нийт 25.1 төгрөгийг хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Аймгийн ЗДН хөрөнгөөс 6132.7, орон нутгийн хөгжлийн сангаас 900.0, ахмадын сангаас 600.0, үйл ажиллагааны орлого 258.0 нийт 7890.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс аймгийн хэмжээнд аялал жуулчлалын салбарт стандартчилал хийх томилолт шатахууны зардалд 6132.7, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 600.0, аймгийн наадмын хяналт шалгалтын зардалд 900.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 258.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 30 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 12 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	5,585,241.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	393,062.00	
3	Албан шаардлага өгсөн	1	1,577,394.90	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	9	7,555,698.70	

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1.Шатахууны зардлыг тооцон олгохдоо холбогдох автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 393.0 мянган төгрөгийг олгосон нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын холбогдох заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Санхүүгийн тайлан, бараа материалын тодруулга тайлан дахь аж ахуй материалын дүн тооллогоорх аж ахуй материалын дүнгээс, 1550.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, санхүүгийн тайлан, бараа материалын тодруулга тайлан дахь барилгын засварын материалын үлдэгдэл няравын тайлан дахь үлдэгдлээс 27.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц бусад асуудал илэрсэнгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар Өмнөх аудитаар 3 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2006 оноос хойш батлагдсан дүрэм, журамтай холбогдуулан шинэчлээгүй нь НББ-ийн тухай хуулийн 18.2 дахь заалттай бүрэн нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

НББББ-ийг байгууллагын үйл ажиллагаа болон шинэчлэн батлагдсан хууль дүрэмд нийцүүлэн дахин боловсруулан батлах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Орлого данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бэлнээр хураан авсан нийт 1312.6 мянган төгрөгийг тухай бүр төвлөрүүлэхгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.12, 8.1-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, ашиг сонирхлын зөрчил үүсэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бичиг хэргийн зардлаас мэдээлэл сурталчилгааны зардалд 66.0, улсын маягтын зардлаас 585.0, бараа үйлчилгээний бусад зардлаас 237.0, хичээл үйлдвэрлэл дадлагын зардлаас 60.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, хог хаягдал зайлуулах зардлаас 117.9 мянган төгрөгийг урсгал засварын зардалд нийт 1304.7 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулж Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл:

Зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх

3.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

4. Зардал данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Автомашин дуудлагаар хэрэглэхдээ 2500 см³-ээс дээш хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжтай автомашин хэрэглэн 417.2 мянган төгрөгийг үргүй зарцуулж Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, холбогдох дүрэм журам зөрчигдөх.

4.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 05 дугаар сарын 11-ний өдрийн тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

5. Зардал данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 600.0 төгрөгийн ахмадын сан байгуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлж Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.2. Эрсдэл:

Зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх, батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, холбогдох дүрэм журам зөрчигдөх.

5.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

6. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн шатахууны зардал 1647.7 мянган төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу эрх нээлгээгүй шалтгаанаас мөнгөн гүйлгээний тайланд бусад бараа ажил үйлчилгээний зардалд бүртгэсэн.

6.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

6.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 7.1 -д заасан "Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

7. Биет бүс хөрөнгийн данстай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:

Программ хангамжид элэгдэл тооцоогүй нь Сангийн сайдын 308 дугаар тушаалын 4.49 дүгээр заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

7.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

7.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 308 дугаар тушаалын 4.49 дүгээр заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

7.4. Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

БУА-2019/125/СТА-ТШЗ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,786,193.64</u>	<u>10,672,079.70</u>
33	АВЛАГА	655,500.00	460,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	655,500.00	460,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,130,693.64	10,212,079.70
354	Хангамжийн материал	9,130,693.64	10,212,079.70
35410	Бичиг хэргийн материал	100,000.00	-
35420	Аж ахуйн материал	9,030,693.64	10,212,079.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>302,193,235.21</u>	<u>278,741,562.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	302,193,235.21	278,741,562.15
392	Биет хөрөнгө	291,863,955.21	268,412,282.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	236,311,280.00	236,311,280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(9,161,115.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,000,000.00	14,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,820,000.00)	(14,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,364,750.00	118,364,750.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,266,411.26)	(78,686,248.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,374,103.00	13,374,103.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,099,766.53)	(11,790,487.37)
393	Биет бус хөрөнгө	10,329,280.00	10,329,280.00
39301	Програм хангамж	303,180.00	303,180.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,026,100.00	10,026,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>311,979,428.85</u>	<u>289,413,641.85</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>686,622.00</u>	<u>2,202,674.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	686,622.00	2,202,674.00
413	Өглөг	31,122.00	1,742,674.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,742,674.00
4136	Бусад өглөг	31,122.00	-

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	18,496.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	12,626.00	-
414	Урьдчилж орсон орлого	655,500.00	460,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	655,500.00	460,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>311,292,806.85</u>	<u>287,210,967.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	311,292,806.85	287,210,967.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,294,986.00	130,294,986.00
51101	Өмч: - төрийн	130,294,986.00	130,294,986.00
512	Хуримтлагдсан үр дүн	(53,220,132.49)	(77,301,971.49)
51210	Өмнөх үеийн үр дүн	(53,220,132.49)	(53,220,132.49)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(24,081,839.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,217,953.34	234,217,953.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>311,979,428.85</u>	<u>289,413,641.85</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	255,546,300.00	244,019,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,768,640.00	35,172,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,768,640.00	35,172,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,768,640.00	35,172,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,768,640.00	35,172,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	225,777,660.00	208,846,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	222,641,900.00	202,114,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	173,081,900.00	201,214,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	49,560,000.00	900,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,200,000.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	3,532,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	3,532,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,135,760.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,135,760.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	219,572,645.25	266,994,505.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	219,572,645.25	266,994,505.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	186,604,648.25	207,724,602.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,684,893.00	126,392,574.00
210101	Үндсэн цалин	111,684,893.00	94,079,374.00
210102	Нэмэгдэл	-	28,155,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,158,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,646,988.00	15,783,421.00
210201	Тэтгэврийн даатгал	11,413,290.00	10,727,321.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,264,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,011,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	252,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,233,698.00	2,528,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,577,580.00	16,516,774.00
210301	Гэрэл, цахилгаан	459,673.00	462,473.00
210302	Түлш, халаалт	15,210,187.00	14,893,581.00
210303	Цэвэр, бохир ус	907,720.00	1,160,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,440,610.00	7,401,028.00
210401	Бичиг хэрэг	1,303,350.00	1,383,550.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	4,847,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	795,978.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	372,660.00	373,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	364,600.00	-
2105	Нормативт зардал	451,800.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	253,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,424,560.00	2,029,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	924,560.00	-
210604	Урсгал засвар	3,500,000.00	2,029,100.00
2107	Томилолт, зочны зардал	11,589,600.00	8,923,287.00
210702	Дотоод албан томилолт	11,589,600.00	8,923,287.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	859,947.00	990,295.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	93,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,820.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	7,027.00	15,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	379,600.00	659,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,928,670.25	29,688,123.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,414,030.00	5,685,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,086,518.00	550,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,428,122.25	23,451,673.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,967,997.00	59,269,903.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,135,760.00	23,839,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,135,760.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22,639,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,768,640.00	35,172,980.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,768,640.00	35,172,980.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	63,597.00	257,123.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,597.00	257,123.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>35,973,654.75</u>	<u>(22,974,825.06)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,640,041.62	1,107,013.94
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,107,013.94
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,640,041.62	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,640,041.62)	(1,107,013.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>32,333,613.13</u>	<u>(24,081,839.00)</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>255,546,300.00</u>	<u>244,019,680.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,768,640.00	35,172,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,768,640.00	35,172,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,768,640.00	35,172,980.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,768,640.00	35,172,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	225,777,660.00	208,846,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	222,641,900.00	202,114,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	173,081,900.00	201,214,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	49,560,000.00	900,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,200,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	3,532,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	3,532,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,135,760.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,135,760.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	206,756,300.00	244,019,680.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,756,300.00	244,019,680.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	173,788,303.00	184,749,777.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,958,781.00	126,375,495.00
210101	Үндсэн цалин	77,414,500.00	94,062,295.00
210102	Нэмэгдэл	19,652,000.00	28,155,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,490,600.00	4,158,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,401,681.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,436,100.00	15,800,500.00
210201	Тэтгэврийн даатгал	8,963,202.00	10,744,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	895,700.00	1,264,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,119,600.00	1,011,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	223,900.00	252,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,233,698.00	2,528,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,977,983.00	14,774,100.00
210301	Гэрэл, цахилгаан	459,673.00	462,473.00
210302	Түлш, халаалт	16,610,590.00	13,150,907.00
210303	Цэвэр, бохир ус	907,720.00	1,160,720.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	6,402,900.00	5,102,900.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	720,496.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	795,978.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	302,900.00	386,426.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	-
2105	Нормативт зардал	494,992.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	296,992.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,272,000.00	3,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	772,000.00	-
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,589,600.00	8,923,287.00
210702	Дотоод албан томилолт	11,589,600.00	8,923,287.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,086,747.00	990,295.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	93,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,820.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
210807	Газрын төлбөр	7,027.00	15,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	558,400.00	659,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,569,200.00	9,583,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,670,700.00	9,032,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	898,500.00	550,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,967,997.00	59,269,903.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,135,760.00	23,839,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,135,760.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22,639,800.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,768,640.00	35,172,980.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,768,640.00	35,172,980.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	63,597.00	257,123.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,597.00	257,123.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,790,000.00	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	48,790,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,790,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	48,790,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	48,790,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(48,790,000.00)	=

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,268,886.00	98,694,030.46	(85,553,745.62)		133,409,170.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,268,886.00	98,694,030.46	(85,553,745.62)	-	133,409,170.84
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	135,523,922.88	-		135,523,922.88
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	10,026,100.00	-	-		10,026,100.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	32,333,613.13		32,333,613.13
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(53,220,132.49)	-	311,292,806.85
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(53,220,132.49)	-	311,292,806.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(53,220,132.49)	-	311,292,806.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(24,081,839.00)		(24,081,839.00)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(77,301,971.49)	-	287,210,967.85

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	201214000.00	200956877.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	201214000.00	200956877.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177974200.00	177717077.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126404900.00	126375495.00
210101	Үндсэн цалин	94091700.00	94062295.00
210102	Нэмэгдэл	28155200.00	28155200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4158000.00	4158000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15800500.00	15800500.00
210201	Тэтгэврийн даатгал	10744400.00	10744400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1264000.00	1264000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1011200.00	1011200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	252800.00	252800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2528100.00	2528100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14774100.00	14774100.00
210301	Гэрэл, цахилгаан	456000.00	462473.00
210302	Түлш, халаалт	13410500.00	13150907.00
210303	Цэвэр, бохир ус	907600.00	1160720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5102900.00	5102900.00
210401	Бичиг хэрэг	800000.00	720496.00
210402	Тээвэр, шатахуун	3200000.00	3200000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	795,978.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	302,900.00	386,426.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	3,200,000.00
210604	Урсгал засвар	3,200,000.00	3,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,923,300.00	8,923,287.00
210702	Дотоод албан томилолт	8,923,300.00	8,923,287.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,218,000.00	990,295.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	121,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	93,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	15,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	660,000.00	659,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,500.00	2,550,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,500.00	550,500.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,239,800.00	23,239,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,239,800.00	23,239,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,639,800.00	22,639,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	201,214,000.00	236,128,980.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	201,214,000.00	201,214,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	201,214,000.00	201,214,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	34,914,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	34,914,980.00